



Бөхийн хичээлийн хөтөлбөрийг сайжруулах судалгааны нэгэн хувилбар

Ү.Шиян Юй^{a*}, Чүн Ян^a, Гончоо Батцэцэг^b, Сувд Туул^c

^a БНХАУ, Хөлөнбуйр аймаг, Хөлөнбуйр Их сургууль, Биеийн тамирын сургууль

^b Монгол улс, Улаанбаатар, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Биеийн тамирын сургууль, Захиргаа

^c Монгол улс, Улаанбаатар, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Биеийн тамирын сургууль, Биеийн тамирын тэнхим

*Холбоо барих зохиогч: xiangyu0470@126.com

Хүлээн авсан: 2020.4.1

Засварласан: 2022.4.25

Хэвлэлтэд авсан: 2022.6.6

Хураангуй

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад дээд боловсролын сургалтын системд зайнаас сургахад суралцагчийг бие даан сургах арга зүйд шилжиж, суралцахуйн үр дүнг суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагаар үнэлэх, онолын мэдлэгийг практик ур чадвартай хослуулах, асуудлыг шийдэх арга замаар багаар ажиллах, харилцааны болон бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, систем бий болгох чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн технологи, арга зүйг эрчимтэй нэвтрүүлж байна. Ажил олгогчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтнийг бэлтгэх нь дээд боловсролын шинэчлэлийн гол асуудал юм. Энэхүү шаардлагад төгсөгчдийн эзэмших ур чадварт хувь хүний болон мэргэжлийн ур чадвар, дадал төлөвшил ба хүмүүстэй харилцах чадварыг багтаасан байдаг. Иймээс бид ӨМӨЗО-ны Хөлөнбуйр Их сургуулийн Биеийн тамирын сургуулийн (БТС) бөхийн хичээлийн хөтөлбөрийг сайжруулах судалгааны ажлын хүрээнд биеийн тамирын дээд сургуулийн оюутнуудаас бөхийн хичээлд оролцох оролцоо, хандлагыг илрүүлэх, харин биеийн тамирын сургуулийн багш нараас бөхийн хичээлийн хөтөлбөрийн бүтэц, агуулга, арга зүй, үнэлгээ, бие даалтын ажлын талаар асуулгын аргыг ашиглан SPSS программаар үр дүнг тооцсон болно. Монгол болон Өвөр монголын биеийн тамирын багш бэлтгэдэг мэргэжлийн сургуулиудын хичээлийн хөтөлбөрт бөхийн спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд биеийн тамирын хичээлийн хөтөлбөрийн агуулгын онолын хувийн жин, кредит цагийг нэмэгдүүлэх, бөхийн мэргэшсэн багш, дасгалжуулагчдыг бэлтгэх хэрэгцээ нэн шаардлагатай гэж дүгнэж байна.

Түлхүүр үг

Хичээлийн хөтөлбөр, монгол бөхийн хичээл, суралцагчдын хандлага, арга зүй



This article is published under the
Creative Commons CC-BY License by 4.0

©2022 Author(s)

Удиртгал

Хятад улс байгуулагдсаны 60 жилийн ойн хүрээнд их, дээд сургуулийн биеийн тамирын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулсан нь биеийн тамирын боловсролын түүхэнд чухал өөрчлөлт болсон юм. 1956-2009 он хүртэлх хугацаанд Хятад улсын боловсролын яамнаас их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийг нийтдээ 5 удаа (1961, 1979, 1992, 2004, 2007) шинэчилсэн байна. Нийгмийн хурдацтай хөгжил, хувьслыг дагаад боловсролын байгууллагууд ч сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөө шинэчлэх, чадварлаг багшийг бэлтгэх асуудалд онцгой анхаарч тодорхой өөрчлөлтүүдийг хийж эхэлсэн. Сургалтын хөтөлбөрийн гол шинэчлэл нь хичээлийн хөтөлбөрийг дээд боловсролын орчин үеийн чиг хандлагатай уялдуулан боловсруулах явдал юм (Ячунь, 2016. х.168).

Хичээлийн хөтөлбөр гэдэг нь тухайн хичээлээр оюутны мэдлэг, чадвар, хандлага эзэмших үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжүүлэх болон үнэлэх арга зүй, хэрэглэгдэхүүнийг тодорхойлсон баримт бичиг мөн (МУБИС, 2020. х.5). Иймд, бид монгол бөхийн хичээлийн хөтөлбөрөөр (Хөлөнбуйр, 2014. х.12), дамжуулан ард түмний бүтээсэн түүх, соёл, үндэсний спортоор бие бялдар, эрүүл мэндээ сахин хамгаалж ирсэн арга технологийг орчин үеийн сургалтын загвартай хослуулан төлөвлөх хэрэгцээ шаардлага байна гэж үзсэн. Монгол бөхийн хичээлийн хөтөлбөрийг сайжруулан боловсруулж, үндэсний өв уламжлалаа сэргээн хөгжүүлэх, тасралтгүй хөгжих боломжийг бий болгож энэ нь урт хугацаанд улс орны хөгжил, ард түмний оюун санаа соён гэгээрэх үйл явцад томоохон хувь нэмрээ оруулах юм.

Өсвөр насандаа спортоор хичээллэх, спортод дур сонирхолтой байх эсэхээс шалтгаалж, насанд хүрэгчдийн насан туршийн биеийн тамирын боловсролд нөлөөлдөг байна (TuijaTammelin.M., SimoNдyhd^b, JaanaLaitinen^a, HannuRintamdk^a, Marjo-RiittaJdrvelin^{bc}, 2019. х.119).

Баялаг түүх, нүүдлийн соёл иргэншлийг бий болгон бүтээсэн Монголчууд үндэсний ёс зүй, ёс суртахууны ариун нандин, үнэт өв уламжлалтай, одоо ч ач холбогдлоо алдаагүй байна. Бидний өвөг дээдсээс өвлүүлсэн төр, иргэний үзэл, ёс, сургаал нь ёс суртахууны боловсрол, хүмүүжлийн үндэсний их өвийг цогцлоодог. Тэдгээр их өв уламжлалаас эгэл энгийн хийгээд иргэний ёс суртахуунд холбогдох ухагдахуун, хэм хэмжээг дээдлэх, өвлүүлэх нь чухал болохыг хэлжээ (Пүрэв.О, 2021. х.72).

Үндэсний бөхийн барилдаан нь олон зуун жилийн түүхэн уламжлалтай, үндэсний шинж чанарыг хадгалан хөгжиж ирсэн гүн гүнзгий утга учир, дэг жаяг бүхий наадмын нэг төрөл юм. Уламжлалт эрийн гурван наадмын нэг болох бөхийн спорт нь бие махбодыг чийрэгжүүлэх, ухаан бодлыг хөгжүүлэх, эрдэм мэхэнд суралцах, найз нөхөрлөлийг бэхжүүлэх, харилцаа холбоог өргөтгөх, нэр төрийг мандуулах, нутаг усаараа овоглодог зэрэг сайн сайхан давуу талтай наадам юм.

Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг бүх шатны боловсролын байгууллага тасралтгүй хийсээр ирсэн бөгөөд энэхүү баримт бичгийн агуулгад үндэсний уламжлалт спортыг тусгаж сургалтын хөтөлбөрөөр дамжуулан өсвөр, залуу үеийнхэнд өвлөн уламжлуулахыг зорьж, монгол бөхийн хичээлийн хөтөлбөрийг боловсронгуй болгоход чиглэсэн судалгааг хийж гүйцэтгэв.

Судлагдсан байдал

Аливаа боловсролын агуулга нь шинжлэх ухаан, технологийн хөгжилтэй уялдаж нийгмийн болон хувь хүний хэрэгцээг хангахад чиглэсээр ирсэн. Сүүлийн жилүүдэд боловсролын салбарт шинэчлэлийн үйл явц эрчимтэй хийгдэж байгаагийн нэг чиглэл нь сургалтын хөтөлбөрийн шинэчлэл юм. Учир нь нийгмийн хэрэгцээ, захиалга өөрчлөгдөхийн хэрээр өнөөг хүртэл хэрэгжиж ирсэн сургалтын хөтөлбөр, түүний чиг хандлага гадаадын хөгжингүй улс орнуудын хөтөлбөрийн ололт амжилтад тулгуурлан хөгжүүлэх шаардлага урган гарч байна. Боловсролын агуулга нь сургалтын хөтөлбөрөөр дамжин практикт хэрэгжих ба сургалтын хөтөлбөр боловсруулахад түүний хэрэгцээг тодорхойлох судалгаанаас эхэлж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш нарын боловсролын түвшний баримт бичиг, стандарт, ном, хэрэгцээг судлан үндэслэлийг гаргана (Дуламсүрэн, 2018. х.29). Сургалтын хөтөлбөр нь хөтөлбөр судлалын үндсэн ухагдахуун болно. Тиймээс ч биеийн тамир, спортын салбарын эрдэмтэд сургалтын хөтөлбөрийн талаар өөрсдийн үзэл бодлыг илэрхийлж, тодорхойлсон байдгаас гадна үндэсний спортыг хөгжүүлэх, сургалтаар дамжуулан монгол бөхийн талаарх мэдлэг, чадвар эзэмших, заан сургах асуудлыг ч хөндөн судалжээ.

Тухайлбал, Өвөр монгол бөхийн аварга, их багш Ү.Содном “Үзэмчин бөх” бүтээлдээ Өвөр Монголын зангиат бөхийг дэлхий нийтийн спортын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан өөрийн уламжлалаа хадгалсан өвөрмөц соёлыг агуулсан спорт болгон дэлгэрүүлэн хөгжүүлэх хэрэгтэй хэмээн дурдсан байна (Содном, 1986. х.24).

Японы эрүүл мэнд, спортын их сургуулийн доктор, профессор багш Ба.Болд зангиат бөхийг хөгжүүлэх гурван шатны бодлогыг гаргаж тавьсан бол судлаач Х.Рашцэрэн зангиат бөхийн үүсэл гарлыг түүх талаас нь судалж Бөх эрдэнэ бүтээлээ номоо туурвижээ.

Монголын бөх судлаачдын бүтээлүүд нэлээдгүй байна. Тухайлбал, судлаач Ж.Дамдин, Т.Халтар, Ш.Гоохүү нар үндэсний бөхийн наадам болон аварга бөхчүүдийн талаар; Ч.Бат-Очир дүрмийн өөрчлөлтийн талаар; Л.Ням-Осор, Б.Батсүх нар Монгол бөхийн хөгжил бүтээлдээ монгол бөхийн барилдааны дүрэм, журмын талаар; Х.Баянмөнх, Ш.Ванчинхүү монгол бөхийн ов мэхийн талаар; Б.Бат-Эрдэнэ үндэсний бөх нь олон мянган жилийн түүхтэй Монголын ард түмний ахуй амьдралаас урган гарсан, эр хүнийг бие бялдар, авхаалж самбаа, тэсвэр хатуужил, ухаан бодол, ёс зүйн талаар төгс төгөлдөр болгон төлөвшүүлэх цогц гүн ухаан, хүн хүнтэйгээ, нийгэмтэйгээ, хүн байгальтай харилцах харилцааны дээд урлаг болох талаас нь Л.Ням монгол үндэсний бөхийн уламжлал технологийн асуудлыг судалж үзсэнээс гадна дараах бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэх, сайжруулах шаардлага байна хэмээн үзсэн байна.

Гадаадын судлаач тухайлбал, Бельги улсын эрдэмтэн Роналда Райсун судалгааныхаа ажилд “Уламжлалт үндэсний спорт нь олон улсын түвшинд зохион байгуулагддаг орчин үеийн спорт үүсэхээс өмнө оршиж байсан спорт юм” хэмээн тэмдэглэсэн бол Волкэр, Кэорнс нар (1990) сургалтын хөтөлбөрийг тухайн мэргэжлийн “мэдлэг, ур чадвар олгох сургалт”-ын цогц хэмээн тодорхойлж авч үзсэн байна.

Улс орнуудын ард түмний спортын сонирхлын ялгаа нь тухайн улсын өв соёл, уламжлал, газарзүйн онцлог зэрэг янз бүрийн хүчин зүйлээс шалтгаалдаг (Yong-Wook Kim, 2022. х 10).

Сэйлор, Александр ба Лювис, Бичамп, Фоснер нар 1981-1998 онуудад сургалтын хөтөлбөрийг сургалтын агуулгын хүрээнд авч үзэн “төлөвлөгөөт суралцах үйл явц”-д үндэслэсэн баримт бичигт, Хирч (Hirsch 1928), Монтинер Адлер (Montiner Adler 1902-2001), Ричард Волкер (Richard Walker 1679–1764) нар өөрсдийн бүтээлдээ хүүхэд, залуучууд, иргэдийг нэгдмэл соёл иргэншилтэй болох зан үйлийг төлөвшүүлэх, эх оронч үзлийг дээдлэх, академик мэдлэг эзэмшүүлэх дэвшилтэт арга, аргачлалд тулгуурласан багшлах технологийг үндэслэн дэвшүүлсэн байна. Сургалтын хөтөлбөр нь академик агуулга, бүтэцтэй суурь мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд чиглэх ёстой гэж үзсэн. Жон Дью (John Dewey 1859-1952), Нэл Ноддингс (Nel Noddings 1928), Вильям Килпатрик (William H. Kilpatrick 1871-1965), Бойд Боде (Boyd Bode 1873-1953) нар суралцагч хүсэл, хэрэгцээ, сонирхолдоо нийцсэн боловсрол эзэмших ёстой гэж үздэг бөгөөд хөтөлбөрийн агуулга нь суралцагчдын сонирхол, асуулт тавих зэргийг өдөөж байхад чиглэгдэх ёстой. Багш, суралцагч хамтран суралцахуйн төлөвлөлтөө гаргах, санал бодлоо солилцох, аливаа асуудлаар шийдэл гаргах боломжийг нээлттэй байлгана. Суралцагчид багшийн хий гэснээр бус, өөрийн туршлага, ойлголтын үндсэн дээр идэвхтэйгээр сургалтад оролцох, хөгжих тохиолдолд тэд сэтгэл ханамжтай байдаг гэж үзжээ.

Дээрх эрдэмтэн, судлаачдын сургалтын хөтөлбөрийн талаар гаргасан үзэл баримтлал, тодорхойлолтод суралцагч хүсэл, хэрэгцээ, сонирхолдоо нийцсэн боловсрол эзэмших, үнэлгээ нь хөтөлбөр боловсруулалтыг зөвлөмжийн дагуу дахин сайжруулах, бие даан амжилттай суралцах үйл ажиллагааг дэмжсэн, багш суралцагчдын хамтын үйл, мэргэжлийн мэдлэг, чадвар олгодог суралцах үйл явцын хамгийн чухал баримт бичиг болохыг чухалчлан авч үзжээ.

Судалгааны арга зүй

Тус судалгаанд Аварга биеийн тамирын дээд сургууль, Үндэсний биеийн тамирын дээд сургууль, Мон-Алтиус биеийн тамирын дээд сургууль, Хөлөнбуйр дээд сургууль, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Биеийн тамирын сургуулиудын нийт 159 оюутнуудаас, бөхийн хичээлийн бүтэц, арга зүй, хэлбэрийн талаар дээрх сургуулийн 53 багшийг хамарсан 13 асуулгаар судалгаа авч, SSPS программ ашиглан дүн шинжилгээ хийн, үр дүнг тооцов. Судалгааг авахдаа оюутны эзэмшсэн байх мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйлийг илрүүлэхэд чиглэсэн асуултуудыг боловсруулж авсан болно.

Судалгааны үр дүн

Судалгаа хоёр хэсгээс бүрдсэн бөгөөд эхний хэсэг нь биеийн тамирын мэргэжлийн оюутнуудаас бөхийн хичээлд хандах хандлагыг (Figure 1-2), хоёрдугаар хэсэгт биеийн тамирын мэргэжлийн багш нараас монгол бөхийн хичээлийн хөтөлбөрийн бүтэц, агуулга, арга зүй, үнэлгээ, бие даалтын ажлын талаар асуулгын аргаар авч үр дүнг тооцлоо.

Table 1
Higher Education Institutions of the Participants Involved

Сургууль	<i>n</i>	%
Аварга БТДС	67	42.14%
ҮБТДС	38	23.90%
Мон-Алтиус БТДС	36	22.64%
Хөлөнбуйр дээд сургууль	18	11.32%
Нийт	159	100

Судалгаанд хамрагдсан оюутнуудыг сургуулиар нь авч үзвэл, 42.14% “Аварга” БТДС-ийн, 23.90% ҮБТДС-ийн, 22.64% “Мон-Алтиус” БТДС-ийн, 11.32% нь Өвөр Монголын Хөлөнбуйр Биеийн тамирын дээд сургуулийн оюутнууд эзэлж байна (Table 1).

Table 2
Professions of the Teachers Involved

Мэргэжил	<i>n</i>	%
Бөхийн багш	0	0%
Мэргэжлийн дасгалжуулагч	8	15%
Биеийн тамирын багш	41	76%
Мэргэжлийн бус багш	5	9%
Нийт	54	100%

Судалгаанд хамрагдсан багш нарын эзэмшсэн мэргэжлийг авч үзвэл хамгийн их буюу 76% нь биеийн тамирын багш, хамгийн бага буюу 15% нь мэргэжлийн дасгалжуулагч байна. Бөхийн багш мэргэжилтэй нэг ч багш байхгүй байгаа нь биеийн тамирын мэргэжилтэн бэлтгэхэд бөхийн багш дутагдалтай байгааг илтгэж байна (Table 2). Хэдий бөхийн мэргэшсэн багш байхгүй ч судалгаанд хамрагдсан багш нар Монгол үндэсний бөхийн спортоо сурах гэсэн хүсэл тэмүүлэлтэй, шавь нартаа сургах хэрэгтэй гэсэн ойлголттой байгаа нь тэдэнтэй хийсэн ярилцлагын дүн харуулав.


Table 3
Duration of the Teaching Experience

Ажилласан жил	<i>n</i>	%
1-5	1	1.84%
6-10	3	5.56%
11-15	18	33.33%
16-аас дээш	32	59.27%
Нийт	54	100%

Судалгаанд хамрагдсан багш нарын мэргэжлээрээ ажилласан жилийг авч үзвэл хамгийн бага жил буюу 1-5 жил ажилласан залуу багшийн эзлэх хувь 1.84%, харин хамгийн их буюу 59.27% нь 16-аас дээш жил ажиллаж байгаа нь тэдний ажлын туршлага, мэргэжлийн ур чадвар тогтворжсоныг илэрхийлж байгаа бөгөөд судалгааны асуулгын үр дүнг тооцох боломжтой (Table 3).

Figure 1

Interest in Studying the Wrestling Course at the IPC



Судалгаанд хамрагдагсдын 56% маш их дуртай. 22% нь дуртай гэсэн бөгөөд нийт үр дүнгээс 78% нь дуртай гэж хариулсан нь бөхийн спортод аль ч насны хүн дуртай болохыг харуулж байгаа юм. Мэргэжлээс үл хамааран бөхийн спортыг улам сонирхдог болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Table 4

Factors Influenced in Choosing the National Wrestling

		Таныг бөхөд сонирхолтой болоход нөлөөлөх хүчин зүйлс										Нийт	
		Авьяас		Хичээл зүтгэл		Оюутны хандлага		Багшийн заах арга зүй		Тоног төхөөрөмжийн хүрэлцээ		n	%
		n	%	n	%	n	%	n	%	n	%		
спортод дуртай	Эцэг, эх	5	13.2	8	9.8	2	22.2	1	3.7	1	50	17	10.8
	Өөрийн сонирхол	2	55.3	36	43.9	3	33.3	11	40.7	0	0	71	44.9
	Орчин	3	7.9	3	3.7	0	0.0	4	14.8	0	0	10	6.3
	Найз нөхөд	0	0.0	6	7.3	0	0.0	0	0.0	0	0	6	3.8
	Багш	2	5.3	5	6.1	1	11.1	2	7.4	0	0	10	6.3
бөхийн спортод дуртай	Үндэсний баяр наадам	3	7.9	11	13.4	2	22.2	4	14.8	1	50	21	13.3
Таныг бөхөд сонирхолтой болоход нөлөөлөх хүчин зүйлс	Бие махбодоо хөгжүүлэх зорилго	4	10.5	13	15.9	1	11.1	5	18.5	0	0	23	14.6
Нийт		38	100	82	100	9	100	27	100	2	100	158	100
Крамерын В коэффициент: 0.198, p=0.03													


Крамерын В коэффициент: 0.198, $p=0.03$

Бөхийн спортод дуртай болоход илүү их нөлөөлдөг зүйл бол өөрийн сонирхол (44.9 %) голлох нөлөөг, бие мах бодио хөгжүүлэх зорилго (14.6 %), үндэсний баяр наадам (13.3 %), эцэг, эх (10.8 %) зэрэг нь тодорхой хэмжээний нөлөөг үзүүлдэг байна. Харин, орчин, багш ба найз нөхөд багахан хэмжээний нөлөө үзүүлнэ. Оюутнууд бөхөд сонирхолтой болоход нөлөөлөх хүчин зүйлсийг нэрлэхдээ нэгдүгээрт хичээл зүтгэл, хоёрдугаарт авьяас, гутгаарт багшийн заах арга зүй, дараа нь оюутны хандлага, эцэст нь тоног төхөөрөмжийн хүрэлцээ гэжээ. Эндээс анзаарвал хувь хүний хичээл зүтгэл буюу хөдөлмөр, төрөлхийн авьяас чухал

хүчин зүйлс бол бөхөөр хичээллэхэд хэрэглэгдэх тоног төхөөрөмжийн хүрэлцээ нэг их чухал биш гэж үзлээ. Дээрх хүснэгтэд үзүүлсэн Камерын В коэффициентын утга 0.198 (статистик ач холбогдол $p=0.03$) буюу бөхийн спортод дуртай болоход нөлөөлсөн зүйлс, бөхөд сонирхолтой болоход нөлөөлөх хүчин зүйлсийн хоорондын хамаарал сул гарсан. Тэгвэл бөхийн хичээлийн хэрэгцээ хэр байгаа вэ? Гэдэг асуултын хариуг олохын тулд судалгааны асуулгадаа оруулсан асуултад анхаарлаа хандуулъя. Судалгаанд хамрагдсан ҮБТДС, Аварга БТДС, Мон-Алтиус, Хөлөнбуйр БТДС-ийн оюутнуудыг харьцуулан үзлээ.

Figure 2

The Significance of the Wrestling Course



Зураг 2-т үзүүлсэн графикаас харахад үндэсний бөхийн барилдаан нь тал нутагт өнө удаан амьдарч ирсэн монголчуудын үнэт зүйл, соёлын өвийн чухал бүрэлдэхүүн хэсэг мөн гэж оюутнуудын 94%, биш 6% хариулжээ. Уг үзүүлэлт үндэсний бөх нь Монголчуудын өв соёлын нэг, уламжлалт спортын төрөл болохыг баталж байна. Өөрөөр хэлбэл, оюутнуудад бөхийн хичээлийг гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ байна.

Table 4

Content Peculiarities of the Wrestling Courses

		Бөхийн хичээлийг зохион байгуулах агуулгын хэлбэрүүдийн эзлэх хувь								Нийт	
		Бөхийн үндсэн мэргэжлээр голлох		Хүчний бэлтгэл голлох		Онолын мэдлэгийг ба дадлагатай хослуулах		Бөхийн тэмцээнийг олон зохион байгуулах		Сурагчдын чадварт тохирсон ялгаатай дасгал хийлгэх	
		n	%	n	%	n	%	n	%	n	%
Сурч буй сургууль	Хөлөнбуйр БТДС	4	22.2	1	5.6	5	27.8	2	11.1	6	33.3
	Аварга БТДС	7	10.4	5	7.5	39	58.2	7	10.4	9	67
	Мон-Алтиус БТДС	10	27.8	1	2.8	15	41.7	4	11.1	6	16.7
	Үндэсний БТДС	18	47.4	1	2.6	11	28.9	6	15.8	2	5.3
Нийт		39	24.5	8	5.0	70	44.0	19	11.9	23	14.5
										9	100

Крамерын В коэффициент: 0.246, $p=0.004$


Оюутнуудын сурч буй сургууль болон бөхийн хичээлийг ямар хэлбэрээр зохион байгуулбал зохимжтой зэрэг нь хоорондоо уялдаа холбоо сул байгааг Крамерын В коэффициентын утга 0.246 ($p=0.004$) илэрхийлж байна. Хөлөнбуйрын оюутнуудын 27.8 %, Аварга Биеийн тамирын дээд сургуулийн оюутнуудын 58.2%,

Мон-Алтиус биеийн тамирын дээд сургуулийн оюутнуудын 41.7% онол болон дадлагыг хослуулбал бидэнд таалагдана хэмээн хариулжээ. Тэгвэл, Үндэсний биеийн тамирын сургуулийн оюутнуудын 47.4% бөхийн үндсэн мэргэжлээр голлосон байвал таалагдана гэжээ. Уг хүснэгтийн доод талын мөр дэх нийт үзүүлэлтийн хувиас харвал, оюутнуудын 44.0% онол ба практик хосолсон, 24.5 % бөхийн бэлтгэл, 14.5% сурагчдын чадварт тохирсон ялгаатай дасгал хөдөлгөөн, 11.9% бөхийн тэмцээн ба 5% хүчний бэлтгэл зонхилсон байвал таалагдана гэсэн хариултуудыг өгчээ. Эндээс, бөхийн мэргэжлээр суралцаж буй оюутнуудын сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа онол ба практик хосолсон, бөхийн мэргэжлийн бэлтгэл зонхилсон хичээлүүдийг төлөвлөх нь зүйтэй гэж дүгнэлээ. Судалгааны дараагийн шатанд асуулгын аргыг ашиглан биеийн тамирын дээд сургуулиудын мэргэжлийн багш нараас баримт мэдээллийг цуглуулав. Судалгаанд нийт 54 багш хамрагдсанаас Хөлөнбуйрын биеийн тамирын дээд сургуульд 46 багш, МУБИС-ийн биеийн тамирын дээд сургуульд 8 багш багшилдаг. Дэлгэрэнгүй байдлаар table 6-д харууллаа. мэргэжлийн бөхийн дасгалжуулагч 6, биеийн тамирын багш 41, багш бус мэргэжилтэй 2 багш судалгаанд хамрагдсан.

Table 5
Professional Backgrounds of the Teachers Involved

		Таны мэргэжил			Нийт
		Мэргэжлийн дасгалжуулагч	Биеийн тамирын багш	Багш бус	
Багшилж буй сургууль	Хөлөнбуйр БТДС	5	40	1	46
	МУБИС-ийн БТС	1	6	1	8
Нийт		6	46	2	54

Figure 2
Significance of Studying Mongolian (National) Wrestling



Мэргэжлийн ангид бөхийн хичээлийг судлах нь тохиромжтой гэж 100 %, мэргэжлийн бус ангид судлах тохиромжгүй гэж 77.4 % хариулсан. Эндээс биеийн тамирын сургуульд бөхийн хичээлийг заавал судлах хэрэгцээ байна, харин мэргэжлийн бус ангид сонгон судлах хичээлийг оюутнуудад санал болгож болно.

Table 6
Time Preference for Studying the Wrestling Course

			Та дээд сургуулийн бөхийн хичээлийг хэддүгээр курсээс судлах нь тохиромжтой						Нийт	
			1-р курс		2-р курс		3-р курс			
			n	%	n	%	n	%	n	%
Багшилж сургууль	буй	Хөлөнбуйр БТДС	7	15.2	31	67.4	8	17.4	46	100.0
		МУБИС- ийн БТС	5	62.5	1	12.5	2	25.0	8	100.0
Нийт			12	22.2	32	59.3	10	18.5	54	100.0

Бөхийн хичээлийг 2-р ангид судлах нь тохиромжтой хэмээн судалгаанд оролцогчдын 59.3 % хариулсан. Хөлөнбуйр сургуулийн багш нарын 67.4 % нь 2-р курсээс, МУБИС багш нарын 62.5 % нь 1-р курсээс бөхийн хичээлийг судлах нь зүйтэй гэжээ.

Table 7
Time Allocation for the Course

		Та дээд сургуулийн бөхийн хичээлийг хэдэн цаг, хэдэн кредитээр суралцах нь тохиромжтой						Нийт	
		24 цаг (1.5кр.)		32 цаг (2 кр.)		48 цаг (2.5 кр.)		n	%
		n	%	n	%	n	%	n	%
Та дээд сургуулийн бөхийн хичээлийг ямар хэлбэрээр судлах нь тохиромжтой гэж үзэж байна вэ?	1 өдөрт 2 цаг, 1 удаа практик	9	56.3	3	18.8	4	25.0	16	100.0
	1 өдөрт 4 цаг, 2 удаа практик	3	60.0	1	20.0	1	20.0	5	100.0
	1 өдөрт 2 цаг, 1 удаа онол, 1 удаа практик	21	63.6	8	24.2	4	12.1	33	100.0
Нийт		33	61.1	12	22.2	9	16.7	54	100.0

Бөхийн хичээлийг судлах тохиромжтой цагийг 24 цаг (1.0 кр) гэж 61.1 % нь хариулсан. Хичээлийн хэлбэрийн хувьд судалгаанд хамрагдсан 54 багшийн 33 нь 1 өдөрт 2 цаг, 1 удаа онол, 1 удаа практик буюу онол ба практикийг хослуулсан хэлбэрээр орохыг санал болгожээ. Бодит байдалд бөхийн хичээлийг 3 болон 4-р курсэд ордог байна. Тухайлбал, Хөлөнбуйр дээд сургуулийн биеийн тамирын багшийн ангид монгол бөхийн хичээлийг 6-р улиралд 18 цагаар 0.5 кредит, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Биеийн тамирын сургуульд үндэсний спорт хичээлийг 7-р улиралд 2 кредитээр судалдаг байна.

Бөхийн хичээлийг онол, дадлага хосолсон хэлбэрээр явуулах нь тохиромжтой гэж багш нарын 61.1 % хариулсан, оюутнуудаас олонх буюу 44 % хариулсан тоон үзүүлэлтүүд давхар баталж байна.

Дүгнэлт

Монгол үндэсний өв уламжлалыг танин мэдэх, судлах, өвлүүлэн хөгжүүлэх асуудлыг чухалчлан авч үзэх, хэрэгцээ шаардлагыг судалсан болно. Бидний хийсэн судалгааны үр дүнгээс харахад Монгол үндэстний онцлог, өв соёлыг агуулсан Монгол бөхийн спортыг залуучууд, хойч үедээ өвлүүлэн үлдээхийн тулд Монгол болон Өвөр монголын биеийн тамирын багш бэлтгэдэг мэргэжлийн сургуулиудын хичээлийн хөтөлбөрт бөхийн спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд биеийн тамирын хичээлийн хөтөлбөрийн агуулгын онолын хувийн жин, кредит цагийг нэмэгдүүлэх, бөхийн мэргэшсэн багш, дасгалжуулагчдыг бэлтгэх хэрэгцээ нэн шаардлагатай байна. БТДС-ийн багш бэлтгэдэг сургуулиудын оюутнууд бөхийн спортыг сонгон буюу заавал судлан суралцах сонирхолтой, бөхийн хичээлийг зохион байгуулалтын хувьд практик хэрэглээг онолын мэдлэгтэй хослуулбал үр дүнтэй гэсэн дүгнэлтийг хийж байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Булган, Б., & Дэлгэрсайхан, Ц. (2017). Бага боловсролын асуудал, шийдэл. *ОУЭШХ-ын эмхэтгэл*, Улаанбаатар х 15.
- БСШУСЯ. (2014). *Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага*. Улаанбаатар., х 3.
- Chernikova, O., Heitzmann, N., Fink, M. C., Timothy, V., Seidel, T., & Fischer, F. (2019). *Facilitating diagnostic competences in higher education - a meta-analysis in medical and teacher education. Educational Psychology Review*, 1–40. <https://doi.org/10.1007/s10648-019-09492-2>
- Ячунь, Л. (2016). Хятад улсын коллежийн англи хэлний сургалтын явцыг үнэлэх нь. *Боловсролын үнэлгээ. ОУЭШХ-ын эмхэтгэл*, Улаанбаатар., х 168.
- МУБИС. *Биеийн тамирын багш боловсролын бакалаврын сургалтын хөтөлбөр*. Улаанбаатар., х 5.
- Хөлөнбуйр. (2014). *Дээд сургууль. Бакалаврын сургалтын хөтөлбөр*. Хөлөнбуйр х 12.
- TuijaTammelin.M.,SimoNдыhd.b.,JaanaLaitinen.a.,HannuRintamdk.a.,Marjo-RiittaJдрvelinbc. (2019). *Physical activity and social status in adolescence as predictors of physical inactivity in adulthood*.
- Пүрэв, О., (2021). *Монголын боловсрол, сургалтыг хүмүүншүүлэх онол, арга зүй*. Улаанбаатар. х 72
- Дуламсүрэн, Ж. (2018). *Сургалтын хөтөлбөрийн хэмжүүр бүтээх судалгаа. Боловсрол судлалын доктор (Ph.D) -ын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл*. Улаанбаатар. х 29
- ӨМҮИС. (2014). *Бакалаврын сургалтын хөтөлбөр*. Хөх хот., х 12.
- Содном, Ү. (1986). *Үзэмчин бөх*. Улаанбаатар., х 25.
- Хөлөнбуйр. (2014). *Дээд сургууль. Бакалаврын сургалтын хөтөлбөр*. Хөлөнбуйр х 12.
- Yong-Wook Kim., Jinyoung Han., Kyungtae Jang., Minsam Ko., Jaewoo Park., Seungyup Lim., Jin-Young Lee. (2022). *He connection to the public's preferred sports analysis and physical education curriculum*. <https://doi.org/10.1371/journal.pone.0264032>

The Study On Improving The Wrestling Course Curriculum

Wu.XiangYu^a, ChunYan^a, Battsetseg Gonchoo^b, Tuul Suvd^c

^aSchool of Physical, Hulunbuir University, Hulunbuir, China

^bAdministration, School of Physical, Mongolian National University of Education,
Ulaanbaatar, Mongolia

^cDepartment of Physical Education, School of Physical, Mongolian National University of
Education, Ulaanbaatar, Mongolia

Corresponding author: xiangyu0470@126.com

Received:4/1/2020

Revised:4/25/2022

Accepted:6/6/2022

Abstract

In recent years, the countries around the world have shifted to the distance self-learning methodologies in which the evaluation of learning outcomes based on students' knowledge, skills, and attitudes as well as such competences as the ability to combine theoretical knowledge with practical skills, the ability to work in teams to solve problems, the ability to develop communication skills, create products, activities and systems have become increasingly significant assessment technologies in the global higher education system (Bulgan and Delgersaikhan, 2017. p 15).

The training process of professionals that meet the needs of employers is a key issue in higher education reform. These requirements include graduates' personal and professional skills, competencies, and interpersonal communication skills (MES, 2014. p 3). Therefore, as part of our research to improve the Wrestling Course Curriculum of the Physical Education Institute, Khulunbuir University (Inner Mongolia, China), we have evaluated students' participation and attitude in wrestling courses as well as physical education teachers' attitude towards the structure, content, methodology, assessment, and self-study assignments of the wrestling courses. The questionnaire results were calculated using SPSS software. We believe that in order to create a positive learning environment for wrestling curricula in the programs of the Mongolian and Inner Mongolian professional institutes, it is necessary to increase the credit hours of and the theoretical weight of the subject in the curricula while training specialized wrestling teachers and coaches.

Keywords

Course program, Mongolian national wrestling class, students' attitude, methodology